

## ПОПУЛИЗМЫН ХӨГЖЛИЙН ТҮҮХЭЭС СӨХВӨЛ

## RE-EXAMINING THE HISTORY OF POPULISM

**Д.БАТЦЭЦЭГ**

Хууль сахиулахын их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад

**BATTSETSEG D.**

(Police Captain) Senior Lecturer of the Department of Social Sciences of the Law and Social Science School, Law Enforcement University

**Товч агуулга:** Та бүхэнд өмнөх нийтлэлээрээ улс төрийн тавцан дахь популист үйлдлийн агуулга, мөн чанарын талаар онолын тодорхой ойлголтуудыг хүргэсэн билээ.

Улс төр судлаачид шилжилтийн үеийн нийгэмд популизм хамгийн хурц илэрдгийг тодруулжээ. Иймээс орчин үеийн популизмыг ойлгохын тулд түүний хөгжлийн түүх, хувьслыг мэдэж байх нь чухал.

Энэ удаагийн нийтлэлээрээ дэлхийн улс орнуудын улс төрийн тавцанд популизм хэмээх нэр томъёо хэрхэн орж ирсэн, өнөөдрийг хүртэл хөгжихдөө түүхэн ямар үйл явцуудаар илрэн гарч байсан, популист үйлдэл үүсэн бий болох ямар урьдач нөхцөлүүд нийгмийн амьдралд бий болж байсан талаарх мэдээллийг дамжуулахыг зорилоо.

**Abstract:** In the previous published article I made certain theoretical aspects of populist operation, its concepts and nature.

Political scientists have considered that populism acutely rises in the period of transitional society. Therefore, to understand the development of modern populism it is important to understand its history and evolution.

In this article, I have tried to explain how the term of "populism" first came into the political arena of countries word wide, how this phenomenon occurred throughout history and what kind of pre-requisite conditions existed for populism to develop in our society.

**Түлхүүр үгс:** Популизм, үндэсний популизм, этнопопулизм, үүсэл хөгжлийн түүх.

**Keywords:** Populism, national populism, ethnopopulism, history of development.

чадахгүй" гэж марксизмын сонгодог онолчид баталдаг<sup>1</sup>. Нэг үндэстний ашиг сонирхлыг хохироон байж нөгөө үндэстэн хөгжин цэцэглэх ёсгүй. Учир нь үндэстэн, төр, нийгэм - энэ бүхэн нь хүмүүсийн харилцан үйлчлэлийн бүтээгдэхүүн, тэдний бүтээсэн нийгмийн харилцааны бүтээгдэхүүн билээ. Тиймээс нийгмийн бүтцийн хөгжлийн түвшин нь хүний хөгжлийн түвшин, түүний амьдралын нөхцөл, ёс суртахуун, соёлоос шууд хамаардаг.

Гэвч хөгжлийн хувьд тогтворгүй улс оронд бүхэл нийгмийн эсвэл үндэстний хүрээнд улс төрийн тусгаар тогтнолоо илэрхийлэх замаар иргэдийг аз жаргалтай болгохыг хүсэх улс төрийн удирдагч гарч ирэхгүй гэсэн ямар ч баталгаа байхгүй юм.

Улс төр судлаачид шилжилтийн үед популизм хамгийн хурц илэрдгийг тодруулжээ. Иймээс орчин үеийн популизмыг ойлгохын тулд түүний хөгжлийн түүх, хувьслыг мэдэж байх нь чухал.

Нэг талаас ардчилсан санаа, туршлагын тодорхой хувилбарууд, нөгөө талаас үндсэрхэг үзлийн чиг хандлагууд хоорондоо нийлж байдаг улс төрийн орон зайд популизмын тодорхой төрөл болох үндэсний популизм (национал-популизм) үүсдэг. Харин ард түмэн голлох үнэт зүйлс нь болдог үндэстний бүлэгт үндэс угсаа нь давамгайлах шинж чанартай болж этнопопулизм үүснэ.

Барууны болон оросын ихэнх эрдэмтэд XIX-XX зууны зааг дахь Америкийн популистуудын үйл ажиллагаанд популизмын эх үүсвэр тусгалаа олсон байдаг гэж үздэг байна.

Популизм үүсэн бий болохын өмнө дараах үйл явдлууд болсон байна.

1861-1865 оны иргэний дайны дараа Америкийн баруун болон өмнөд хэсэг

<sup>1</sup> Энгельс Ф. О. Польше. - В кн.: Маркс К., Энгельс Ф. Сочинения. - 2-е изд. - М., 1955. - Т.4 - С.372



Хууль сахиулахуй

дэх фермийн эзэд хэрэглээний үндсэн бүтээгдэхүүний үнийн байнгын уналтаас алдагдал хүлээж эхэлжээ. Үүний үндсэн шалтгаан нь: нэгдүгээрт, шинэ техник технологи бий болсны улмаас үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэн, хоёрдугаарт, ачаа тээврийн салбарт хувьсгал гарч, Америкийн үйлдвэрлэгчдийг бусад улс орны үйлдвэрлэгчидтэй өрсөлдөхөөс аргагүй байдалд хүргэсэн явдал байв. Америкийн фермийн эзэд эдгээр үндсэн шалтгаанд анхаарал хандуулалгүй харин төмөр замын хэтэрхий их зардал, зээлийн өндөр хүү, механикчид, худалдаачдын үндэслэлгүй өндөр орлого, магадгүй бүр олон улсад ч байж болох мөнгөний хомсдлын ямар нэгэн үгсэл хэлцэлд бурууг тохож байв.

Популизмаас өмнө фермийн эздийн олон цуврал жагсаал, хөдөлгөөн гарч, дундад болон баруун мужуудын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид нь Өмнөдийн хөвөн, тамхины үйлдвэрлэгчдийн дэмжлэгийг авч байв. 1870-аад онуудад фермийн эзэд өөрсдийн анхаарлыг төмөр зам дээр төвлөрүүлж, нэгдсэн улсын хэмжээнд ихээхэн үр дүнд хүрсэн нь холбооны төмөр замын дүрэмд нөлөөлж чадсан юм явдал байлаа. Төмрийн чөлөөт олборлогчид болон түүний ивээн тэтгэгчид эрдэс мөнгөний асуудалд гол анхаарлаа чиглүүлж, нэг бол цаасан мөнгөний хэмжээг ихэсгэх, эсвэл металл мөнгийг алтаар, алтыг мөнгөөр тэнцүүлэн хөрвүүлж солихыг шаардаж байв. Баруун болон Өмнөдөд тус бүр нэг фермийн эздийн холбоо ажиллаж, фермийн эздийн эдийн засгийн төдийгүй улс төрийн харилцаанд оролцох боломжуудыг эрэлхийлж байв.

Эдгээр үндэс суурин дээр үүсэн бий болсон популистууд (тухайн үед үүссэн хөдөлгөөний талынхныг ингэж нэрлэх болжээ) ажилчдын дэмжлэгт багагүй найдвар тавьж байсны зэрэгцээ хөдөө аж ахуй эрхлэгчдийн ашиг сонирхолд үйлчлэх нам байгуулахыг эрмэлзэж байжээ. Тэдний эсрэг эдийн засаг, аж үйлдвэрийг хянаж байсан плутократууд болон тэр үед засгийн эрхэнд үйл ажиллагаа явуулж байсан хэт хуучинсаг үзэл баримтлал бүхий улс төрийн намууд зогсож байв.

1880-аад оны сүүлч, 1890-ээд оны эхээр Баруун болон Өмнөдийн захын дүүргүүдийн фермийн эздийн байдал хүндэрч эхэлжээ. Баруун тийш шилжин нүүдэллэсэн ч эдийн засгийн хувьд ямар ч ашиггүй болж, баруун зүгийн дөчин наймдугаар уртрагийн нутаг дэвсгэр лүү шилжсэн боловч тэнд жилийн хур тунадасны хэмжээ маш бага байлаа.

Өмнөдийн фермийн түрээслэгч эзэд үнийн байнгын уналтын зэрэгцээ өөрсдийн эзэд болон бөөний худалдаачдын өрсөлдөөнийг давж гарахын тулд байгаа бүх хүчээ шавхан ажиллаж байжээ. Гэвч энд өөр нэг хүчин зүйл байсан юм. Захын баруун хязгаарын мөнгө олборлогчид мөнгөний үнэ ханш унаж байгаад маш их дургүйцэж байсны шалтгаан нь 1873 оноос АНУ алтны нэгдсэн ганц стандарт барьж, мөнгө металл ямар ч үнэ ханшгүй болсонтой холбоотой байв. Европын зарим улс орнууд АНУ-ыг алтны стандартад барих чиглэлийг батална гэж тодорхойлж байсан нь мөнгийг бизнесээс гаргах олон улсын хуйвалдаан зохиож байна гэсэн хардлагыг төрүүлж байв.

Ядуурч хоосорсон фермийн эзэд болон олон тооны ажилчдын сэтгэл зүйн өөрчлөлт, хүсэл сонирхлыг тэр үед улс төрийн тавцанд үйл ажиллагаа явуулж байсан нийгмийн зүтгэлтнүүд олж харснаар 1891 оны 5 дугаар сарын 19-нд Ардын (популист) намыг байгуулжээ.

Популист хөдөлгөөн нь тэр үед бүрэлдэн бий болсон хөрөнгөтний монополист ноёрхлын эсрэг тэмцэлд арьс өнгө, үндэс угсааны ялгаагүйгээр нийгмийн гишүүдийн (гол төлөв фермийн эзэд ба ажилчдын) ашиг сонирхлыг нэгтгэж байв. Монополийн жижиг үйлдвэрлэлд үзүүлэх нөлөөллөөс үүдсэн дампуурал, түүний үр дагаврын хохирогч болсон Америкийн ажилчид зэрэг олон нийтийн санаа бодол энэ хөдөлгөөнөөр илэрхийлэгдэж байв. Хөдөлгөөний үйл явц нь хар аяндаа урсгалаараа гарч ирвэг байсан бөгөөд зохион байгуулалтын хувьд эмх замбараагүй хэлбэрээр илрэн гардаг. Энэ байдлаа онол, зохион байгуулалтын хатуу хэв шинж нь "Төр засаг нь ард түмнээс холдох шинж тэмдэг" гэж үзлээр тайлбарлаж байлаа. Энэ ч утгаараа популист хөдөлгөөн нь бүхэлдээ энгийн хар ухаанаар хөгжиж иржээ.

Хэдийгээр энэ хөдөлгөөн нийгмийн орчин нөхцөлөөсөө хамааран урсгалаараа хөгжиж байсан ч АНУ-ын нийгмийн хөгжлийн чиг хандлагад тохирох олон чухал, шинэ санааг оруулж ирсэн юм.

Популист хөдөлгөөний хөтөлбөрт чиг хандлага Омахский (1892), Спрингфельдский (1894) нарын тунхаглалд дэвшүүлэгдсэн байдаг.

Популист санааны өвөрмөц байдал нь:

Нэгдүгээрт, "ард түмэн ба ардын засаг" гэсэн ойлголтын шинэ агуулга,

Хоёрдугаарт, төрийн чиг үүргийн талаарх шинэ үзэл бодол,



Гуравдугаарт, ард түмнийг засгийн үйл ажиллагааг удирдахад шууд оролцуулах төлөөллийн ардчилал ба шууд ардчиллыг хослуулах замаар ардчилсан байгууллыг өргөжүүлэх шаардлага зэрэг үндсэн суурь аспектиудаар тодорхойлогддог.

Популистуудын санал болгосон ард түмэн ба ардын засгийн тухай ойлголт нь хөрөнгөтний ардчиллын сонгодог ойлголтуудаас ялгагдаж байв. Тэдний хувьд нийгмийн дээд үнэ цэнэ нь ард түмэн гэх нийсвэр ойлголт бус, харин “хот тосгонд ажиллаж байгаа жинхэнэ ард түмэн, хөдөлмөрч түмэн юм”.

Америк уламжлал бүхий сулхан төвлөрсөн засгийн эсрэг хөдөлмөрч ард түмний ашиг сонирхлын тулд үйлчилдэг, ард түмний шууд хяналтын доор ажилладаг хүчтэй төрийн санааг популистууд дэвшүүлэн тавьсан юм.

“Популист гүн ухаан нь эцсийн дүндээ:

1. Ядуу зүдүү, дутагдаж гачигдаж байгаа хүмүүсээр ашиг олдог хүмүүсийн амин хувиа бодсон ашиг сонирхлыг засгийн газар нь хязгаарлан барьж байх ёстой,

2. Баян цатгалан, нэр нөлөөтэй хүмүүс (плутократ) бус харин ард түмэн засгийн газрыг хянаж байх ёстой” гэсэн үндсэн хоёр байр суурийг илэрхийлдэг” гэж Ж.Хикс бичжээ<sup>3</sup>.

Популист хөдөлгөөний гол зорилгыг ажилчдын нөхцөл байдлыг сайжруулах хэмээн тодорхойлж, эдийн засгийн салбарт төрийн зохицуулагч үүргийг нэмэгдүүлэх замаар зорилгодоо хүрч болно гэж үзэж байв.

Популизмын хамгийн ширүүн шүүмжлэгчдийн нэг, Америкийн нэрт түүхч Р.Хофстедтер хүртэл “Популистууд АНУ-д ноёрхож байсан төрийн үүрэг, байр суурийн талаар үзэл бодлыг дахин нягталсан” гэж түүний давуу талыг хүлээн зөвшөөрдөг. “Популизм бол төр бүх нийтийн сайн сайхны төлөө хариуцлага хүлээх ёстой гэж шаардсан хамгийн томоохон улс төрийн хөдөлгөөн байсан” хэмээн тэрээр бичжээ<sup>4</sup>.

Өнгөрсөн зууны 90-ээд оны популистууд олон нийтийн хөдөлгөөний түвшин дэх орчин үеийн улс төрийн гүн ухааны хамгийн гол асуудлуудын нэг болох ардчилал ба төрийн нийгмийн хариуцлагын харьцааг мэдэрч, тодруулан гаргаж ирсэн юм.

Нийгмийн өмнө хүлээх төрийн хариуцлага бол ардчилсан хяналтын оновчтой механизм бүхий хүчтэй гүйцэтгэх засаглал байх явдал юм.

Популистууд зөвхөн улс төрийн оролцооны санааг дэвшүүлэн гаргаад зогсохгүй энэ санааны тодорхой шинэчлэлийг хангахуйц тогтолцоог ч санал болгосон. “Популизм нь сенатын шууд сонгууль, төлөөлөгчдөөр дамжуулан хууль тогтоомжийн эрхийг сонгогчдод өгдөг, хууль тогтоох байгууллагуудын үйлдэлд хориг референдум /бүх нийтийн санал асуулга/ хийх зэрэг шууд ардчиллын механизмыг боловсруулсан гэж Америкийн судлаач Э.Голдмен бичиж байв<sup>5</sup>.

Популист хөдөлгөөний ардчилсан хэв шинж Америкийн өмнөд мужуудад хамгийн ихээр дэлгэрч, аж үйлдвэр, санхүүгийн магнатуудын хэмжээгүй эрх мэдлийн эсрэг тэмцэлд хар, цагаан арьстнуудын эвслийг бий болгосон нь арьс өнгөний үзлийн гол үүр уурхай болсон Өмнөдөд аболитионизмын (ямар нэгэн хууль, дүрмийг устгах нийгмийн хөдөлгөөн) уламжлалыг үргэлжлүүлсэн юм. Арьс өнгөний үзлийн эсрэг уран илтгэгч популистуудын хэлсэн үгэнд, хар арьст популист лидерүүдийг хамгаалах, тэдний үйлдэлд тэдний үйлдлийг өндрөөр үнэлсэн санаанууд ихээр агуулагдаж байв. Жоржиа мужийн конгресс дахь популист манлайлагчдын нэг Т.Уотсен “Та бүхнийг бие биенээ үзэн ядахад хүргэж албадаж байгаа, учир нь энэ үзэн ядалт бол хар, цагааныг ялгалгүй боолчилдог санхүүгийн деспотизмын гол хэрэгцээ юм” гэж хэлж байв<sup>6</sup>.

Хар арьст лидерт аюул тулгарахад түүнийг цагаан арьст фермийн эзэд зэвсэг барин хамгаалсан тухай түүхт жишээгээр Жоржиа мужийн популистууд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг эв нэгдлийн чухлыг тунхаглаж байжээ<sup>7</sup>.

Популизм нь нийгэм улс төрийн асуудлаар зөвхөн хязгаарлагддаггүй. Энэ хөдөлгөөн нь ертөнцийг үзэх үзэл, сэтгэл зүй, гоо сайхны бүхий л давхаргыг хамарч байдаг. Популист ухамсар нь рациональ онолын бус, харин зөн совин, энгийн ухамсрын прагматик үүднээс ертөнцийг үзэх үзэл болон бие хүний байр суурийг тодорхойлж, улс орны түүхэн хувь заяанд

<sup>2</sup> Nugent W.T.K. The Tolerant Populists. Chicago, 1963. -P.233-234

<sup>3</sup> Hicks J.D. The Populist Revolt: A History of the Farmers Alliance and the People's Party. Minneapolis, 1931. -P.407

<sup>4</sup> Hofstadter R. The Age of Reform. From Bryan to FDR. N.Y., 1955. - P.61

<sup>5</sup> Goldman E.F. Rendezvous with Destiny. A History of Modern American Reform. N.Y., 1956.-P.46

<sup>6</sup> Цит. no Chandler D.L. The Natural Superiority of Southern Politicians. Garden City, 1977.-P.213

<sup>7</sup> Populism: Reaction or Reform? Ed by Saloutos T.Huntington. N.Y., 1978. - P.45



МОНГОЛЫН  
АМЬСГААР  
ХУУЛЬ  
САХИУЛАХУЙ

өөрийн гэсэн чиг хандлагаар илэрдэг.

Бүрдүүлсэн тодорхой үзэл суртал, онолын суурьгүй ч популизм нь өөртөө гайхалтай хослолыг агуулсан байдаг: Нэг талаас, энэ нь өөрийн гэсэн тодорхой хөтөлбөртэй улс төрийн прагматик урсгал, нөгөө талаас нэгэн төрлийн уламжлалт оюун санаа юм. Нийгэм, ертөнцийг авах популист ойлголтод нийгмийг баян ба ядуу, ард түмэн ба сонгогдогчид гэсэн энгийн хуваалтаар ангилдаг. Популист ухамсар нь утопи иррационализмаар тодорхойлогддог. Энэ нь нэг эсвэл хэд хэдэн энгийн аргын тусламжтайгаар нийгмийг бүхлээр нь эрс өөрчлөн, сайн сайхан болгох боломжтой гэсэн эдийн засгийн болон улс төрийн хэнээрхлээр илэрхийлэгддэг.

Популизмын үзэл сурталд бие хүний тухай асуудал чухал байр эзэлдэг. “Эдийн засаг, улс төр, тэр ч байтугай нийгэм бүхлээрээ популист үзэл суртлын гол төв биш. Түүний төв бол бие хүн, цаашилбал хүний ёс суртахууны тал юм” гэж английн судлаач Д.Макрэ бичжээ<sup>8</sup>. Энэ санаа нь “нийгэм, эдийн засгийн бодлогын гол зорилт нь энгийн хүний аз жаргал, түүний материаллаг баялаг, сайн сайхан, оюун санааны өв тэгш зохицол гэж тооцдог” популист ертөнцийг үзэх үзлийн тод илрэл юм. Дээрх үзэл санаа марксизм, либерализмын зарим үзлүүдэд нийтлэг тусгагдсан байдаг. Гэхдээ марксизмд хувьсгалт өөрчлөлтийн тусламжтайгаар үүнд хүрч болно гэж үздэг бол либерализмд хувийн өмчийн онолын үүднээс тайлбарладаг. Харин популизм нь бүх асуудлыг хамгийн энгийн арга замаар ийм төгс зохицлыг хэрэгжүүлэх боломжтой хэмээн итгэж найддаг, нэг буюу нэлээд хэдэн арга хэмжээ нийгмийг бүхэлд нь сайн сайхнаар өөрчилж чадна гэж итгэдэгт оршино.

Популист ертөнцийг үзэх үзэлд хамгийн энгийн, нэгдмэл хүний хосгүй жишиг загвар бол газрын эзэн, фермерын эзэн байдаг. Үүнээс үндэслэн популистууд капиталист аж үйлдвэржилтийг хурцаар шүүмжилж, хотжилтын эсрэг тэмцдэг. Тэд нэгдсэн улсуудын дотор байгаль орчны асуудлыг хөндөж тавьсан хамгийн анхны хөдөлгөөн байсан. Гэвч тэдний шүүмжлэл нь техникжүүлэлтийн эсрэг шинж чанаргүй байв. Тэд техникийн хөгжлийг дэмжиж, түүнийг үйлдвэрлэл болон хөдөө аж ахуйн хөдөлмөрийг хөнгөвчлөхийн тулд нэвтрүүлэхийг дэмжиж байсан ч аж үйлдвэрийн магнатууд техникийн хөгжлийг

<sup>8</sup> Populism. Its Meanings and National Characteristics. Ed. by Jonescu G., Gellner E. L., 1969.-P.159

эрх мэдлээ улам хүчтэй болгоход ашиглаж байна гэдэгт санаа зовж байв.

Популизмд, жирийн хүний дээд жишиг загварыг хүчтэй бие хүнтэй холбон тайлбарладаггүй. Популист бие хүний дээд жишиг стандарт бол Генри Торогийн тодорхойлсноор “ой доторх амьдралаар” амьдарсан тусгаарлагдсан дээд жишиг биш, харин бие хүн өөрийгөө дээд зэргээр хөгжүүлэх боломж бүхий ардчилсан нийгмийн үйл ажиллагааны төсөөллөөр илэрхийлэгддэг.

Хамгийн өндөр боловсролтой популист манлайлагчдын нэг Т.Ньюджент өөрийн хэлсэн үгнүүддээ энэ санаагаа илэрхийлж байв: “Нийгмийн Хүнийг хувиргах, алдаршуулахын тулд энэ ертөнц рүү дээрээс илгээгдсэн бурхны хувьслын эцсийн үр дүн нь Христос байгаагүй гэж үү?”<sup>9</sup>. Эдгээр үгс тэр үеийн Америкчуудын хувьд дасаагүй үгс байсан төдийгүй хачин сонин санагддаг байжээ.

Популист хөдөлгөөний үед жирийн Америк хүний нийгмийн идэвхтэй үйл ажиллагаагаар бие хүн хөгжиж өөрийгөө илэрхийлэн тодруулдаг. Өөрийнхөө хувь заяанд нөлөөлөх боломжоос түлхэгдэж дорд үзэгдсэн олон сая ажилчдын хувьд энэ хөдөлгөөн нь тэдэнд өөрсдийгөө нийгэмд хэрэгтэй, ач холбогдолтойгоо мэдрэх сэтгэлийг өгч байв. Энэ нь бусдаас онцгой, ардчилсан, дотоод сэтгэл, мэдрэмжээр илэрхийлэгдсэн соёлыг бүрдүүлсэн юм. Ардчилсан оролцоо ба хяналтын популист үзэл санаа нь энэхүү соёл-ертөнцийг үзэх үзэл бодлын үндэс суурийн улс төрийн илэрхийлэл байв.

АНУ-ын популист ухамсар нь олон тооны онцлогтой. Үүнд: Америкийн амьдрал дахь сөрөг үзэгдлүүдийг илчлэхдээ оновчтой бөгөөд шийдвэртэй хандахын зэрэгцээ хамгийн популистууд өөрийнхөө системийн үндсэн зарчмуудад үнэнч байв. Жишээ нь, тэд хувийн өмчийн зарчмыг буруутгаагүй, харин ч түүнийг бие хүний зүй ёсны эрх, төгс сайн нийгмийн үндэс суурь гэж үзсэн. Тэд үйлдвэрлэлийн харилцаа, нийгмийн ангиудын ялгарлыг ноцтой асуудалд тооцоогүй нь тэдэнд нийгэм дэх эсрэг тэсрэг байдал, сөргөлдөөн тэмцлийн талаарх төсөөлөл байгаагүй гэсэн үг. Үүнээс үндэслэн, популистууд нийгмийн асуудлыг хүч хэрэглэх аргаар шийдвэрлэхийг үгүйсгэдэг байсан гэж хэлж болно.

Популист ертөнцийг үзэх үзлүүд хэдийгээр эсрэг тэсрэг зөрчилтэй байсан ч

<sup>9</sup> Godwin L. The Populist Moment: A Short History of the Agrarian Revolt in America. N.Y., 1978.-P.192-193

тэд энгийн хүмүүсийг өөрсдийнх нь хувь заяаг шийдэх аливаа асуудалд оролцуулах зорилго бүхий нийгмийн бүтцийг бий болгох, түүнчлэн монопольчлолын эсрэг чиг хандлага, арьс өнгөөр ялгаварлахгүйгээр нийгмийн бүх гишүүд тэгш эрхтэй байх үзэл санаа зэргийг дэвшүүлэн тавьсан нь популист хөдөлгөөнийг бүхэлдээ ардчилсан чиг баримжаатай үзэгдэл гэж тодорхойлох боломжийг олгож байгаа юм.

Хэдийгээр хуучин бүтэц байгууллыг эвдэхэд чиглэгдсэн үйл ажиллагаанд үзүүлж буй хариу үйлдэл, томоохон капиталист үйлдвэрлэгчдийн эсэргүүцэлтэй тулгарч байсан ч Америкийн популизм нь өнгөрсөн үе рүү чиглээгүй юм. Харин ч эсрэгээрээ популист ухамсар нь өөрийн цаг үеийн шаардлагыг нарийн ойлгож, тэр ч байтугай заримдаа нэлээд хэдэн арван жилээр түрүүлэн харж байсан. Үүний үр дүнд өнөөдрийг хүртэл ач холбогдлоо бүрэн гүйцэд хадгалж байгаа: эдийн засгийн талаарх тодорхой зорилгод олон нийтийн улс төрийн хөдөлгөөний аргаар хүрэх, энэ хөдөлгөөнд арьс өнгө ялгаварлахгүйгээр энгийн ард иргэд оролцох, ардчилсан оролцоо ба хяналт, хүрээлэн буй байгаль орчноо хамгаалах хадгалах, бие хүний өв тэгш хөгжил зэрэг АНУ-ын ардчиллын хөгжлийн үндсэн чиглэлүүд бий болсноор баталж болох юм.

Хэдийгээр сайн сайхан олон чанарыг өөртөө агуулж байсан ч популист хөдөлгөөний гишүүд дэмжигчид албан бус, тооны хувьд тодорхойгүй байсны улмаас өөрсдийн дэвшүүлж байсан үндсэн зарчмуудыг бие даан хэрэгжүүлж чадаагүй.

Популист хөдөлгөөн нь 1896 оны ерөнхийлөгчийн сонгуульд У.Брайаныг дэмжсэний дараа ардчилсан намын бүрэлдэхүүнд оржээ. Чухамхүү энэ үеэс л олон түмний энгийн ухамсарт нөлөөлөх, тэдний шаардлагыг хэрэгжүүлж, нийцүүлж байгаа мэтээр харагдуулах, нийгмийн амьдралын тухай төсөөллийг хялбарчлах, аливааг шууд хүлээн авах, хэтрүүлэх, энгийн бөгөөд нэг утгатай улс төрийн шийдвэр гаргах зэрэг улс төрийн тэмцэлд баримтлах тактикийн байр суурийг илэрхийлэх "ПОПУЛИЗМ" хэмээх нэр томъёог У.Брайаны нэртэй эцсийн байдлаар холбосон юм.

Популизм нь АНУ-ын улс төрийн тавцанд хэд хэдэн удаагийн ялалтыг байгуулсан боловч түүний мөрийн хөтөлбөр нь улсын хэмжээн дэх ерөнхий асуудлыг хөндсөн шинж чанартай байсан учраас эдгээр түр зуурын ялалтууд нь үр дүн багатай байв.

1900 онд Ардчилсан нам задарч ардчиллыг дэмжигч болон эсэргүүцэгчид талуудад хуваагдан, ардчилалтай "эвлэрээгүй" фракц нь Пенсильван мужийн Вартон Баркерыг ерөнхийлөгчийн суудалд, Миннесота мужийн Игнатиус Доннеллийг дэд ерөнхийлөгчийн суудалд дэвшүүлжээ. Энэ фракц нь 1912 он хүртэл АНУ-ын ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн жагсаалтыг дэвшүүлсээр байснаар барахгүй АНУ-ын ерөнхийлөгч асан Теодор Рузвельт, Вудроу Вильсон нарын үед популистуудын олон шаардлагыг биелүүлсэн байдаг.

1930-аад оны үед мөн л АНУ-д популизм хурцаар өрнөж байсан юм. Энэ бол 1929-1933 оны дэлхийн эдийн засгийн хямралын араас дагасан "их уналт" гэж нэрлэгддэг үе байлаа. Капитализмын түүхэнд хамгийн урт удаан хугацаанд үргэлжилсэн, хамгийн их сүйрэл хөнөөлтэй байсан энэ хямрал нь ард түмний амьдралын түвшинг урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр унагааж, нийгмийн олон талт хөдөлгөөнүүдийг өдөөж, популизмыг сэргээн гаргаж ирсэн юм. Энэ үед явуулж байсан нийгмийн салбарын зарим нэг шинэчлэлтэй хамт эдийн засгийн болон төрийн зохицуулалтыг хүчтэй болгох арга хэмжээг хослуулсан ерөнхийлөгч Т.Рузвельтын засгийн газрын арга хэмжээний систем нь "Шинэ курс" гэсэн нэртэй байсан нь популизмын шинэ эхлэл байсан юм.

### ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Ц.Ганболд. Улс төрийн сэтгэл судлал ба хүчирхийллийн сэтгэл зүй. УБ., 2004.
2. Ц.Мөнхцэцэг. Политайнмент буюу цэнгээнт улс төр. УБ., 2010
3. Политология: Энциклопедический словарь. - М., 1993
4. Хоце Ортега-и-Гассет. Түмний түрэлт. Орч. Ч.Энхээ. УБ., 2001
5. Populism: Its Meanings and National Characteristics. Ed. by Jonescu G., Gellner E. -L., 1969
6. Jonescu G., Gellner E. Introduction. - In: Populism: Its Meanings and National Characteristics. -L., 1969
7. Populism: Reaction or Reform? Ed by Saloutos T. Huntington. N.Y., 1978
8. Godwin L. The Populist Moment: A Short History of the Agrarian Revolt in America. N.Y., 1978